

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/168/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор М.Нурболат

Утас: 9902-7275, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 273

танай _____-ны № _____-т

СЭРГЭЛЭН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөрөнгийн тооллогыг хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2. "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудал байна. Үүнд: Бараа материалын дансанд бүртгэлтэй 64.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, баталгаажаагүй дүнг санхүүгийн тайланд тусгасан байна.

011020387

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,983,761.94	95,767,269.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	78,170.54	37,405,771.48
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	78,170.54	37,405,771.48
3121	Төгрөг	78,170.54	37,405,771.48
31211	Төрийн сангийн харилцах	78,170.54	37,405,771.48
35	БАРАА МАТЕРИАЛ	37,905,591.40	58,361,497.52
351	Түүхий эд материал	12,616,663.00	29,245,681.00
35110	Тусгай зориулалттай материал	478,318.00	1,491,960.00
35130	Эм боох материал	12,138,345.00	27,753,721.00
354	Хангамжийн материал	25,165,728.40	29,115,816.52
35410	Бичиг хэргийн материал	722,160.00	685,700.00
35420	Аж ахуйн материал	812,000.00	1,676,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	687,420.00
35460	Хүнсний материал	273,000.00	3,000.00
35470	Бусад хангамжийн материал	23,358,568.40	26,063,696.52
35500	Биологийн хөрөнгө	123,200.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	458,309,741.20	485,157,426.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	458,309,741.20	485,157,426.43
392	Биет хөрөнгө	422,309,741.20	449,157,426.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	340,805,920.63	340,805,920.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,993,335.52)	(19,833,241.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,506,834.00	67,106,834.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,355,671.35)	(31,978,410.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	126,215,333.56	148,587,559.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,183,708.39)	(58,294,104.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,491,850.00	14,379,220.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,177,481.73)	(11,616,351.81)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,428,400.00	4,428,400.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,428,400.00)	(4,428,400.00)
393	Биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	496,293,503.14	580,924,695.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	496,293,503.14	580,924,695.43
51	Засгийн газрын хувь оролцоо	496,293,503.14	580,924,695.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	294,572,263.12	294,572,263.12
51101	Өмч: - төрийн	294,572,263.12	294,572,263.12
512	Хуримтлагдсан үр дүн	98,873,896.81	183,880,426.89
51210	Өмнөх үеийн үр дүн	498,370.42	99,249,234.60
51220	Тайлант үеийн үр дүн	98,375,526.39	84,631,192.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,847,343.21	102,472,005.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	496,293,503.14	580,924,695.43

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	638,055,278.66	450,594,751.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	243,944,878.66	71,712,071.41
120	Нийтлэг татварын бус орлого	243,944,878.66	71,712,071.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	243,944,878.66	71,712,071.41
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	243,944,878.66	71,712,071.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,110,400.00	378,882,680.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	353,467,600.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,467,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,550,000.00	4,840,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,550,000.00	4,840,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,092,800.00	15,558,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	15,558,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	12,092,800.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	358,484,380.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	358,484,380.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	539,679,752.27	365,963,559.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,679,752.27	365,963,559.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,995,112.61	365,766,189.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,951,262.91	225,103,147.80
210101	Үндсэн цалин	257,144,231.11	155,652,967.94
210102	Нэмэгдэл	-	49,884,721.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,404,998.88
210104	Урамшуулал	807,031.80	16,160,459.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,539,371.69	29,045,338.11
210201	Тэтгэврийн даатгал	24,263,646.18	20,622,358.14
210202	Тэтгэмжийн даатгал	2,708,866.27	2,354,930.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,136,853.03	1,840,264.81
210204	Ажилгүйдлийн даатгал	493,636.93	384,343.94
210205	Эрүүл мэндийн даатгал	4,936,369.29	3,843,440.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,311,100.34	10,489,130.84
210301	Гэрэл, цахилгаан	1,981,844.34	2,395,913.84
210302	Түлш, халаалт	7,896,756.00	7,643,217.00
210303	Цэвэр, бохир ус	432,500.00	450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,781,870.00	15,534,640.00
210401	Бичиг хэрэг	770,980.00	1,926,460.00
210402	Тээвэр, шатахуун	10,597,390.00	10,214,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	541,200.00	934,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,596,600.00	1,976,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	275,700.00	482,400.00
2105	Нормативт зардал	173,908,693.70	46,656,281.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	165,678,843.70	34,715,581.15
210502	Хоол, хүнс	8,229,850.00	11,004,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	936,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,743,700.00	5,795,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	143,700.00	-
210604	Урсгал засвар	1,600,000.00	5,795,000.00
2107	Томилот, зочны зардал	350,000.00	2,170,400.00
210702	Дотоод албан томилот	350,000.00	2,170,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	414,075.00	1,737,782.00

**Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	82,575.00	82,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	28,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210807	Газрын төлбөр	-	75,207.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,995,038.97	29,234,470.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,335,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,995,038.97	27,899,470.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,684,639.66	197,369.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,639.66	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,639.66	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	197,369.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	197,369.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>98,375,526.39</u>	<u>84,631,192.29</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>98,375,526.39</u>	<u>84,631,192.29</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>394,110,400.00</u>	<u>378,882,680.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	365,560,400.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	365,560,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	353,467,600.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	12,092,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,550,000.00	378,882,680.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,550,000.00	4,840,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,550,000.00	4,840,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	15,558,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	15,558,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	358,484,380.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	358,484,380.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>394,032,229.46</u>	<u>341,555,079.06</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,032,229.46	341,555,079.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,347,589.80	341,357,709.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,069,135.65	225,103,147.80
210101	Үндсэн цалин	153,088,692.09	155,652,967.94
210102	Нэмэгдэл	79,845,312.33	49,884,721.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,674,988.19	3,404,998.88
210104	Урамшуулал	23,460,143.04	16,160,459.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,746,872.16	29,045,338.11
210201	Тэтгэврийн даатгал	24,614,903.88	20,622,358.14

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	2,484,810.19	2,354,930.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,158,218.09	1,840,264.81
210204	Ажилгүйдлийн даатгал	499,158.14	384,343.94
210205	Эрүүл мэндийн даатгал	4,989,781.86	3,843,440.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,408,160.34	10,365,930.84
210301	Гэрэл, цахилгаан	1,981,844.34	2,395,913.84
210302	Түлш, халаалт	7,976,316.00	7,520,017.00
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,456,630.00	16,785,600.00
210401	Бичиг хэрэг	851,240.00	1,890,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,154,140.00	10,902,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	541,200.00	934,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,614,350.00	2,186,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	295,700.00	872,900.00
2105	Нормативт зардал	43,608,116.65	46,849,511.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,754,016.65	34,689,211.15
210502	Хоол, хүнс	7,854,100.00	10,564,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,596,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,923,700.00	6,365,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	323,700.00	570,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	5,795,000.00
2107	Томилолт, зочны зардал	350,000.00	2,170,400.00
210702	Дотоод албан томилолт	350,000.00	2,170,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	414,075.00	1,737,782.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	82,575.00	82,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	28,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210807	Газрын төлбөр	-	75,207.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,370,900.00	2,935,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,370,900.00	2,935,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,684,639.66	197,369.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,639.66	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,639.66	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	197,369.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	197,369.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	78,170.54	37,327,600.94
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	78,170.54	37,327,600.94
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	78,170.54
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,170.54	37,405,771.48

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	498,370.42	397,917,976.75
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	498,370.42	397,917,976.75
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	98,375,526.39	98,375,526.39
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	98,873,896.81	496,293,503.14
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	98,873,896.81	496,293,503.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	375,337.79	375,337.79
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,572,263.12	102,847,343.21	99,249,234.60	496,668,840.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(375,337.79)	-	(375,337.79)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	84,631,192.29	84,631,192.29
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,572,263.12	102,472,005.42	183,880,426.89	580,924,695.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	408,307,900.00	341,357,709.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	408,307,900.00	341,357,709.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,307,900.00	341,357,709.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,296,400.00	225,103,147.80
210101	Үндсэн цалин	174,965,800.00	155,652,967.94
210102	Нэмэгдэл	81,054,800.00	49,884,721.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,795,000.00	3,404,998.88
210104	Урамшуулал	23,480,800.00	16,160,459.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,537,000.00	29,045,338.11
210201	Тэтгэврийн даатгал	24,165,200.00	20,622,358.14
210202	Тэтгэмжийн даатгал	2,843,000.00	2,354,930.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,274,300.00	1,840,264.81
210204	Ажилгүйдлийн даатгал	568,600.00	384,343.94
210205	Эрүүл мэндийн даатгал	5,685,900.00	3,843,440.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,558,300.00	10,365,930.84
210301	Гэрэл, цахилгаан	2,373,300.00	2,395,913.84
210302	Түлш, халаалт	7,735,000.00	7,520,017.00
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,886,900.00	16,785,600.00
210401	Бичиг хэрэг	1,877,200.00	1,890,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,903,100.00	10,902,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	945,000.00	934,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,186,600.00	2,186,200.00

**Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	975,000.00	872,900.00
2105	Нормативт зардал	46,858,900.00	46,849,511.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,689,300.00	34,689,211.15
210502	Хоол, хүнс	10,569,600.00	10,564,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,600,000.00	1,596,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,460,800.00	6,365,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	660,800.00	570,000.00
210604	Урсгал засвар	5,800,000.00	5,795,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,790,000.00	2,170,400.00
210702	Дотоод албан томилолт	2,790,000.00	2,170,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,933,700.00	1,737,782.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,000.00	950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,500.00	82,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,800.00	-
210807	Газрын төлбөр	150,400.00	75,207.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	360,000.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,985,900.00	2,935,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,985,900.00	2,935,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	408,307,900.00	378,685,310.84
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,558,300.00	15,360,930.84
122005	Орон нутгийн төсвөөс	15,558,300.00	15,360,930.84
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,918,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,918,200.00	
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	387,831,400.00	363,324,380.00
122001	Хандив тусламж /дотоод/	387,831,400.00	363,324,380.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	78,170.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,170.54	37,405,771.48

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ хүн амд үзүүлэх, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай үзүүлэх амьдралын баталгааг хангахад чиглэгдэнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84.6 сая төгрөгөөр буюу 17.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	78.2	37,405.8	37,327.6
Бараа материал	37,905.6	58,361.5	20,455.9
Үндсэн хөрөнгө	458,309.7	485,157.4	26,847.7
Нийт хөрөнгө	496,293.5	580,924.7	84,631.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	496,293.5	580,924.7	84,631.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	496,293.5	580,924.7	84,631.2

Дээрх хүснэгтээс харахад тайлант хугацаанд харилцах дансанд 381.1 сая төгрөгийн орлого орж 343.8 сая төгрөгийн зарлага гарч 37.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 58.4 сая төгрөг болж 20.4 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд бараа материал 90.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 69.7 сая төгрөгийг зарцуулалт хийгдэж, цэвэр дүнгээр 20.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд эм боох материал 15.6 сая төгрөгөөр, хангамжийн материал 2.7 сая төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөөлсөн байна.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 485.2 сая төгрөг болж 26.8 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд 54.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант хугацаанд 27.8 сая төгрөгийн элэгдлийн хэмжээгээр буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 580.9 сая төгрөг болж 84.6 сая төгрөгөөр өссөн нь тайланд хугацааны ашигтай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 387.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 387.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр 372.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 15.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 358.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 37.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 325.9 сая төгрөг буюу 83 хувьтай байгаа нь цалин хөлс нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлын төсвийг 37.4 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэлээр зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайланд хугацаанд нэмэлт дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудит менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 365.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус байгууллага нь төв нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 мэдээ хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 26.9 сая төгрөгийн дүнг мэдүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь 33.0 сая төгрөгийн худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 төлбөрийн акт, 6 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 93.5 хувь байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	667.3	1	667.3	100.0
Албан шаардлага	6	516,475.8	1	483,008.1	93.5
Нийт дүн	7	517,143.1	1	483,675.4	93.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд: Үндсэн хөрөнгөд 0.9 сая төгрөгийн элэгдлийн зардал буруу тооцсон, 3.4 сая төгрөгийн бараа материалын ажил гүйлгээг ангилал буруу дансанд орлогод авсан, зарлага гаргасан, 29.7 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг тушаал шийдвэргүй данснаас хассаныг бүртгэл, тайланд буцаан тусгуулсан болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитаар нийт 541.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.3 сая төгрөгт 2 төлбөрийн акт, 541.0 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн эмийн санчид эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй 269,934.8 төгрөгийн цалин хөлс олгосон байна Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно гэж заасныг тус тус зөрчсөн байна..
2. Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь ажил гүйцэтгэх гэрээгээр ажилласан ажилтнуудад олгосон 0.5 сая төгрөгийн ажлын хөлснөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.”, 14 дүгээр зүйлийн 14,1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна.” 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:”, 7.1.6-д “үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй 58.4 сая, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 482.6 сая, нийт 541.0 сая төгрөгийн хөрөнгөд тооллого хийгээгүй, баталгаажуулж дүнг санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				/мянган төгрөгөөр/ Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацаанд худалдаж авсан бараа материалыг харгалзах дансанд бүртгээгүй	1	3,455.1			1	3,455.1	1	3,455.1			-	-
Сумын ЗДТГазарт шилжүүлсэн гэх үндсэн хөрөнгийг тушаал шийдвэргүй данснаас хассан.	1	29,736.4			1	29,736.4	1	29,736.4				
Хөрөнгийн анхны өртөг, ашиглалтын хугацааг буруу тодорхойлсноос тайлант хугацааны элэгдлийн зардал буруу илэрхийлсэн	1	933.3			1	933.3	1	933.3				
Дүн	3	34,124.9	-	-	3	34,124.9	3	34,124.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эмийн санч эргэлтийн эмийн сангаас цалинждаг бөгөөд 2022 оны 4-р сард ЭМТ-өөс цалин олгосон.	1	269.9	1	269.9								
Хувь хүнд олгосон 500,000 төгрөгийн ажлын хөлснөөс ХХОАТ суутгаагүй.	1	50.0	1	50.0								
2022 оны жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, эрх бүхий албан тушаалтан тооллогын ажлын шийдвэр гаргаагүй, тооллогын ажил зохион байгуулаагүй.	1	541,057.2			1	541,057.2						
Дүн	3	541,377.1	2	319.9	1	541,057.2	-	-	-	-	-	-

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд 5 мэдээ хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний дүнг мэдүүлээгүй	1	26,905.9			1	26,905.9		
Дүн	1	26,905.9	0	-	1	26,905.9	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн төлбөрт цахим төлбөрийн баримт шивүүлээгүй	1	33,038.1			1	33,038.1		
Дүн	1	33,038.1	0	-	1	33,038.1	0	-
Нийт дүн	2	59,944.0	0	-	2	59,944.0	0	-